

Хөгжмийн багшийн түүвэрт сонгогдсон хүүхдийн гүйцэтгэх даалгавар-багшид

Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Бага	
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: Хөгжим	
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I	Танин мэдэхүйн түвшин: Задлан шинжлэх	
Илрүүлэх чадвар: Амьтдын дуу чимээг сонсоод зургийг заана.	Интеграци эсэх: Үгүй	
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай	
Даалгавар	“Энэ ямар амьтан дуугарсан бэ?”	
Хэрэглэгдэхүүн	Хүүхдийн хамгийн сайн мэддэг амьтан болон заасан сургалт, үйл ажиллагааны үед танилцсан 5 амьтны дуутай аудио бичлэг бэлдэж болно. Өгөгдсөн бичлэгийг ашиглах бол: 5 хошуу малын зурган картыг бэлтгэнэ. https://www.youtube.com/watch?v=GmIKTKXMhuY	
Даалгаврын заавар	Амьтдын дуу чимээг нэг нэгээр нь сонсоно. Багш ширээн дээр зурган картыг байрлуулсан байх бөгөөд хүүхэд тохирох амьтны зургийг заана. Хүүхэд сонссон амьтны зургийг сонгосны дараа дараагийн амьтны дууг сонсоно.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> - Багш нь нэг зураг харуулъя. Сайн хараарай. - Энэ ямар амьтан бэ? Чи мэдэх үү? - Одоо нэг чимээ сонсоё. Зурган дээр байгаа амьтан байвал зургийг нь заагаарай. - Багш нь дараагийн амьтны дууг сонсоё. Анхааралтай сонсоорой. Ямар амьтан дуугарсан бэ? Зургийг заагаарай. 	<p>Багш бичлэгийг сонсож, ярилцана.</p> <p>Хүүхэд амьтадын дуу чимээг сонсохыг зургийг зааж байгааг ажиглана.</p>
Дэмжлэг	Хүүхэд дуу чимээг сонсоод тохирох зургийг заах оролдлого хийгээгүй, эргэлзсэн тохиолдолд багш дөхүүлсэн асуултыг асууж дэмжлэгийг үзүүлнэ.. Хүүхэд буруу хариулт өгсөн тохиолдолд зөв дуу чимээг дахин сонсоно.	
Анхаарах зүйл	Хүүхдийн анхаарал сарниулах үйлдэл болон чимээ гарсан тохиолдолд дахин сонсоно. Дараагийн дуу чимээг сонгохын өмнө анхааруулах үгсийг хэлнэ.	

Даалгаврын дугаар: 2		Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I		Танин мэдэхүйн түвшин: Ойлгох
Илрүүлэх чадвар: Дууны үгийг багшийг дагаж аялгуулан хэлж дуулна, хөдөлгөөнийг дуурайна.		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	“Хамтдаа дуулья”	
Хэрэглэгдэхүүн	“Бугын байшин” дуу: https://www.youtube.com/watch?v=ILeujasxDac Багшийн заасан хүүхдийн мэддэг хөдөлгөөнт дууг ашиглах, дууны аяыг багш хөгжимдөж болно.	
Даалгаврын заавар	Багш өөрөө дууг биечлэн дуулж үзүүлнэ. Үгийг дагуулан хэлнэ. Багштайгаа хамтаа дуугаа дуулж, дууны утга санааг илэрхийлж, дүрүүдийн хөдөлгөөнийг хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> - Багш нь нэг дуу сонсоё. Сонсоорой. - Багш нь дууг дуулна. Анхааралтай сонсоорой. - Чи энэ дууг сонсож байсан уу? мэдэх үү? - Багшийгаа дагаад үгийг хэлээд, хөдөлгөөнийг дуулаарай. 	Багш өөрөө хамтдаа дуулна. Хүүхэд дууны аялгуунд үгийг хэлж дуулан хөдөлгөөн хийж байгаа эсэхийг ажиглана.
Дэмжлэг	Хүүхэд эргэлзэх болон тогтож сонсох, харахгүй байгаа тохиолдолд дууны дүрс бичлэгийг үзүүлэх эсвэл багш дахин 1 удаа дууг дуулж өгч болно. Дууг хамтдаа дахин нэг дуулна.	
Анхаарах зүйл	Хүүхэд багшийн даган дуулахдаа дууны үгийг аялгуулан дуулж хөдөлгөөн хийж байгааг ажиглана.	

Даалгаврын дугаар: 3		Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I		Танин мэдэхүйн түвшин: Ойлгох
Илрүүлэх чадвар: Дууны хэмнэлд тохируулан алгаа ташна, дороо алхана.		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	“Дагаад хийгээрэй”	
Хэрэглэгдэхүүн	“Би жагсаж чадна” Ая: С. Батболд Үг: С. Соронзонболд https://www.youtube.com/watch?v=d3RSM6pwQS4&list=PL067Gy6CN9mvF4Zl3zfwS1jmlFLi-ooHb	
Даалгаврын заавар	Дууны бичлэгийг үзүүлэхгүйгээр сонгоно. Багш өөрөө биечлэн хөдөлгөөнийг хийж дуулж үзүүлнэ. Багштайгаа хамтдаа хөгжмийн хэмнэлд дороо алхана.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> - Багш нь дуу сонсгоё. - Дууны аянд багш нь яаж алга ташиж байгааг хараарай. - Багштайгаа хамтдаа хийж үзье. - Дахин нэг хамтдаа хийе. 	Хүүхдийн дууг сонсгоно. Дууг дуулж аянд дороо алхаж үзүүлнэ. Хүүхэд дууны аялгуунд дороо алхаж байгаа эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
Дэмжлэг	Хэмнэлийг жигд хийхэд нь дэмжлэг үзүүлэх. Хөгжмийн аянд алга таших оролдлого хийж байхад нь урамшуулна.	
Анхаарах зүйл	Хүүхдийн дуу болон хөгжмийн аяыг багш өөрөө сонгоно. Үйлдлийг хийхэд яаруулахгүй байна.	

Даалгаврын дугаар: 4		Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй		Сургалтын чиглэл: Хөгжим
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I		Танин мэдэхүйн түвшин: Бүтээх
Илрүүлэх чадвар: Хөгжмийн аянд багшийг дагаж хөдөлгөөнийг хийхийг оролдоно.		Интеграци эсэх: Үгүй
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр		Даалгаврын хэлбэр: Задгай
Даалгавар	“Адилхан би”	
Хэрэглэгдэхүүн	https://www.youtube.com/watch?v=kGcXj2xNQKw	
Даалгаврын заавар	Багшийн хөдөлгөөнийг хүүхдүүд даган дуурайж хийнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> - Багш нь нэг дууны ая сонсгоё. - Дууны аянд багш нь хөдөлгөөн хийнэ. Анхааралтай хараарай. - Багшийгаа дагаад хөдөлгөөн хийхийг оролдоорой. 	Дууны аянд хөдөлгөөнийг 1 удаа хийж үзүүлж, ямар хөдөлгөөнөөр юуг илэрхийлж байгаа тухай ярилцана. Үүний дараа хүүхдийг дагуулан хөдөлгөөнийг дахин хийнэ.
Дэмжлэг	Хүүхэд эргэлзэх болон тогтож сайн, харахгүй байгаа тохиолдолд багш хамтдаа дахин нэг удаа хийнэ. Хүүхэд хөдөлгөөнийг хийх явцад багш үгээр чиглүүлэг өгч болно.	
Анхаарах зүйл	Үнэлгээний баг дууны аяыг сонгохдоо багшийн заасан дууны жагсаалтаас сонгоно. Сонгосон дууны аяыг ашиглана.	